

БАТЛАВ:

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА



Ж.ЦОЛМОН

ШИНЖЛЭН ШАЛГАХ АЖИЛЛАГААГ ХЭЭРИЙН
НӨХЦӨЛД ЯВУУЛАХ ДАДЛАГА, СУРГАЛТЫН
УДИРДАМЖ

Зорилго: Ослын газар дээрх байгаль, цаг агаарын хүнд нөхцөлд шинжлэн шалгах ажиллагааг саадгүй явуулах болон уг ажиллагаанд оролцож байгаа шинжлэн шалгагч ба ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад дадлага сургалтын зорилго оршино.

Хээрийн нөхцөлд ажиллах байршил: Дадлага сургалтыг аль болох хүн, суурин газраас зайдуу хол, өндөр уулархаг, бартаа саад ихтэй газрыг олж очихоор сонгон явуулна. Уг сонголтонд нийцүүлэн Хайртхаан амралтын газрын ойролцоо осолдсон бага оврын агаарын хөлгийг эрэн хайж олоход агаарын навигацийн зураг, GPS ашиглан байрлалыг олж тогтоон ослын газарт түр байрлах штабын байрлалыг зохион байгуулж 2025 оны 05 дугаар сарын 29-30 -ны өдөр сургалт явуулж зохион байгуулах.

Сургалтын чиглэл:

Дадлага сургалтаар дараах үндсэн 5 бэлэн байдлын шалгуурыг тогтооно. Үүнд:

- Ослын газарт хүн хүч, ажлын болон ахуйн тоног төхөөрөмжийн хамт аль болох саадгүй хурдан хүрч очих ажлын зохион байгуулалт газрын зураг GPS ашиглах.
- Ослын газарт хээрийн штаб байгуулж Шинжлэн шалгах ажиллагааг хийх, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ажлуулж бүртгэж шалгах.
- Хээрийн нөхцлийн ажлын байрны бэлэн байдал түүний төхөөрөмжүүдийн хамгийн бага байж болох хугацаа хэрэгцээг тодорхойлох.
- Хээрийн нөхцөлд амьдарч ажиллах ахуйн хэрэгцээний эд зүйлийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.
- Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн эрсдэлийг газар дээр нь судлах хэрэгцээг тодорхойлох.

Сургалтын хөтөлбөр

Сургалт, дадлагыг дараах хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Өглөө бүх ажиллагсад 08.00-д Буянт Ухаа дахь ажлын байранд цугларсан байна.

08.00-08.30 хооронд агаарын хөлгийн осол гарсан мэдээлэл хүлээн авч газрын зураг болон АТС болон COSPASS бусад мэдээллийн хэрэгслээс хүлээн авна.

Албаны дарга шинжлэн шалгагчид болон албан хаагчдыг ослын тухай урьдчилсан яриаг яаралтай хуралдуулж ажлын төв байранд үлдэх шинжлэн шалгагч, хүн хүчний тооцоо, шинжлэн шалгагч, мэргэжилтэнгийн ажлын хувиарийг тодруулан хүн тус бүрийг үүргээр хангаж хяналтын хуудсыг шаардлагын дагуу бэлтгэж өгсөн байна.

Ослын газрын солбицол координатыг тодруулан нислэгийн зураг 500.000 дээш масштабын зурагт очих газрын нислэгийн навигацийн тооцоог хийсний дараа ослын газарт шуурхай очих шинжлэн шалгагчдыг АХОЗШША-ны даргын тушаалаар томилно.

Албаны дарга ослын газрын шинжлэн шалгагчдын явах унаа, нисдэг тэргийг урьдчилан бэлтгэсэн гэрээний дагуу хувийн авиакомпаниуд болон агаарын цэргийн хүчний аврах ангитай холбоо барьж, нислэгийн чиглэл болон нислэгийн цагийн тооцоог санхүүгийн алба баталгаажуулна.

Шинжлэн шалгагчид болон мэргэжилтэн ажиллагсад бие бүрэлдэхүүн, явах унаа болон нисдэг тэргэнд ослын үед хэрэглэх албаны хэрэгцээт бүх эд хогшил, ариутгах бодис, майхан сав, аяны хөнжил, хэрэглэгдэх бэлэн мөнгө, данс, идэх хүнсний нөөцийг бэлтгэн ачуулж бэлэн болгосон байна.

Ослын газарт ажиллах томилогдсон шинжлэн шалгагчид биологийн халдвар, хамгаалалтад анхаарч нэг удаагийн ариутгагч бодис, сургалтад хамрагдсан гэрчилгээ зэргийг шаардлагын дагуу бэлэн болгоно.

09.00-09.30 Ослын газарт ажиллах баг бүрэлдэхүүнийг ослын газар руу явуулах, нислэгийн шинжлэн шалгагчийн тооцооны дагуу ослын газрыг хайж олох.

11.00-11.30 Шинжлэн шалгах баг тоног төхөөрөмжийн хамт ослын газрын орчимд тээврийн хэрэгслээр очих, ослын байршил, ослын үлдэгдлийг хамгаалалтад авах.

Ослын газарт ажиллах шүүх цагдаагийн, эмнэлэгийн болон ОБЕГ-ын ажилтнуудын байрлах газрын байрлалын зургийг гаргах, аврах нисдэг тэрэг бууж хөөрөх талбайг сонгох,

- 13.30-14.00 Хээрийн нөхцөлд ажиллах хувийн хэрэгсэл, хамгаалалтын цэгүүдийг байгуулах бэлтгэх, бэлэн болгох нийт бүрэлдэхүүн оролцоно- ахлах шинжлэн шалгагч дадлагажуулна.
- 14.00-15.00 Хээрийн нөхцөлд ажиллах, амьдрах зорилгоор авч явах хувийн болон албаны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлэн болгоход нийт бүрэлдэхүүн оролцоно- ахлагч шинжлэн шалгагч, техникийн шинжлэн шалгагч, мэргэжилтнүүд дадлагажуулна.
- 15.30-16.00 Шинжлэн шалгах ажиллагаанд оролцогч нарт хөдөлмөр хамгаалал, эмнэлэгийн хэрэгслэл ариутгал, туяа болон халдварт өвчингөөс урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх- ахлах шинжлэн шалгагч

Шинжлэн шалгах баг тоног төхөөрөмжийн хамт ослын газрын орчимд тээврийн хэрэгслээр очих,

Хээрийн ажлын байрыг бэлэн болгох, байрлах

2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр

11.00-12.00 Ослын газарт шинжлэн шалгах ажиллагааг эхлүүлэх, эд мөрийн баримтуудыг олж тогтоох, хэмжих хэрэгслүүдээр эд мөрийн баримтуудын байршлуудын зайг хэмжих дадлага, сургалт хийх- ахлах шинжлэн шалгагч

12.00-13.00 Хээрийн нөхцөлд цай, хоол бэлтгэх сургуулилалт, зохион байгуулалт, хүн бүр оролцоно -ахлах шинжлэн шалгагч зааварчилна.

Богино долгионы хэрэгслийн ажиллагааг төрөл бүрийн байршил уулын ар, өвөр, бэл, оройгоос ярианы алслалтын чадавхыг шалгах, ажиллагаанд суралцах хүн бүр оролцоно- техникийн шинжлэн шалгагч

Иридум утсыг байршилж байгаа газар, ослын газар буюу уулын оройгоос Улаанбаатар 99154533, 71285099 дугаар руу залгаж шалгах, хүн бүр зааврын дагуу ажиллуулж сурах -нислэгийн шинжлэн шалгагч

13.00-14.00

Хээрийн нөхцөлд хоол унд бэлтгэх дадлага сургалт, оройн хоол хүн бүр оролцоно- ахлах шинжлэн шалгагч зааварчилна.

Хээрийн нөхцөлд амьдрах чадвар, бодит байдал дээрх хээрийн нөхцөлд амьдрах байр, ариутгал, хоол унд, сандал ширээ, унтах хэрэгсэл, ажлын багаж, тоног төхөөрөмж, ажлын хувцас г.м бусад зүйлсийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, ахлах шинжлэн шалгагч зааварчилна. Бэлэн байдлын сургалтын хэлэлцүүлэг, дүгнэлт яриаг УБ-т ажлын байранд явуулна.


Буцах бэлтгэл ажил хангах, Оройн хоол

15.00-17.00

Улаанбаатар

Удирдамж, төлөвлөгөөг бэлтгэсэн:

Нислэгийн шинжлэн шалгагч:



Ч.Буянбадрах

**Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны дадлага
сургуулилтыг хээрийн нөхцөлд явуулсан ажлын тайлан.**

2025.06.02.

Хээрийн сургуулилтыг явуулах болсон шалтгаан:

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Чикагогийн конвенцийн 13 дугаар Хавсралт Шинжлэн шалгах ажиллагаанд шинжлэн шалгагч нарын бэлэн байдлыг хангах, ICAO Circular 298-AN/172 “Training Guidelines for Aircraft Accident Investigators”, “Manual of Aircraft Accident and Incident Investigation” DOC 9756, P1-ийн, 5.4, 5.5 дахь заалтын дагуу хээрийн нөхцөлд ослын газарт ажиллах дадлага сургалтыг үндэслэн агаарын хөлгийн ослын үеийн бэлэн байдалд үр дүнтэй дүгнэлт хийх, цаг агаарын хүнд нөхцөлд шинжлэн шалгах, ажиллагааг саадгүй явуулах, уг ажиллагаанд оролцож байгаа шинжээч ба ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл аюулгүй байдал, хувцас хэрэгцээт багаж эрүүл ахуйг хангах зорилгоор дадлага сургалтыг зохион байгуулав.

Хээрийн сургалтын ажиллах байршил: Дадлага сургалтыг аль болох хүн, суурин газраас зайдуу хол, уулархаг, газрыг олж очихоор сонгон авч явуулав.

Олон улсын Конвенцид нийцүүлэн Хайртхаан амралтын газрын ойролцоо А310 агаарын хөлгийг эрэн хайж олоход агаарын навигацын зураг, GPS ашиглан байрлалыг олж тогтоон, шинжээчдийн бэлэн байдал томилгоог албаны даргын удирдамжийг үндэслэн, 2025 оны 05 дугаар сарын 29–30-ны өдөр явуулахаар тохиролцож шийдвэрлэв.

Тус дадлага сургуулилтад:

Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах албанаас:

Ерөнхий шинжлэн шалгагч, албаны дарга Ж. Цолмон

Ахлах шинжлэн шалгагч Х.Наранхүү

Шинжлэн шалгагч Ч.Буянбадрах

Шинжлэн шалгагч Ч.Шинэбаяр

Шинжлэн шалгагч П.Гэрэлчимэг

Шинжлэн шалгагч Г.Ганхуяг

Санхүү, нягтлан бодогч Х.Баярмаа

Бүртгэл, судалгааны мэргэжилтэн С.Баттулга

Бичиг хэрэг туслах ажилтан О.Тэгшжаргал нар оролцов.

Сургалтыг урьдчилан боловсруулсан сургалтын хөтөлбөр, хяналтын картын дагуу гүйцэтгэсэн.

2025 оны 05 дугаар сарын 29-ны 08:00 мин-д ослын нислэгийн шуурхай яриаг ажлын өрөөнд ахлах шинжээчийн удирдлаган доор хийж, N48° 02.25, E106° 20.04 солиболцолд агаарын хөлөг осолдсон тухай мэдээлийг АТС болон олон улсын бусад системүүдээс хүлээн авч газрын зураг дээр нислэгийн штурманы тооцоог хийж, байрлалыг ойролцоогоор тогтоосон.

Багийн ахлагч, шинжлэн шалгагч нарын хувийн бэлтгэл ажлыг хангах дадлага сургалт, ослын газрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт, зааварчилгаа, очих газар /ослын газар/-ыг газрын зургаас олох, явах зай хэмжээг тогтоох дадлага сургалт зохион байгууллаа.

Ослын байршил: N48°0225 E106°2004 Хайртхаан уулаас баруун урд талд Баянчандмань сумаас урд зүгт 25 км шороон замаас баруун талд 450м газар далайн түвшнээс 1627м өндөр ууланд осолдсон болохыг сансрын GPS системийг ашиглан тогтоов.

Ослын газрын Цаг агаар, агаарын хөлгийн хөдөлгөөн, нар орох гарах /04:59-20:40/ цагийг тодорхойлов.

Ослын байршил дадлагын өгөгдөхүүн:

A310 агаарын хөлөг Улаанбаатараас 48км-т Буянт-Ухаа аэродромын агаарын хөлгийн 3 дугаар эргэлтийн бүс болох Хайрт хаан уулын районд осолдсон болохыг тогтоож, агаарын хөлгийн ослын байршлыг илтгэгч Kannad 406 ELT төхөөрөмж ослын давтамж 121.5 МГц үелзлээр 10 мин турш сигнал дохио өгч унтарсан гэсэн мэдээлэл авсан.

Ослын тухай нислэгийн шуурхай яриан дээр бие бүрэлдэхүүнд тус тусын үүрэг хариуцлагыг тодотгож шинжлэн шалгагчдын багийг АХОЗШША-ны даргын тушаалаар томилж, ослын газарт хээрийн штаб байгуулах, шинжлэн шалгах ажиллагааг хийх, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрдүүлэх, хээрийн нөхцөлд амьдарч ажиллах ахуйн хэрэгцээний эд аж ахуй, хоол хүнсний нөөцийг бэлэн болгов. /Хугацаа 0:40 мин/

Албаны дарга, ослын газрын шинжээчдийн явах унааг, /нисдэг тэрэг/ урьдчилан бэлтгэсэн гэрээний дагуу хувийн авиакомпаниуд болон агаарын цэргийн хүчний аврах ангитай холбоо барьж нислэгийн чиглэл болон нислэгийн цагийн тооцоог тооцоолж, санхүүгийн алба баталгаажуулав.

Шинжээчид болон мэргэжилтэн ажиллагсад бие бүрэлдэхүүн, явах унаа /нисдэг тэрэг/ ослын үед хэрэглэх албаны хэрэгцээт бүх эд хогшил, майхан сав, аяны хөнжил, идэх хүнсний нөөцийг бэлтгэж ачуулж бэлэн болгов. /Хугацаа: 0:30мин/

09:35 минутанд бие бүрэлдэхүүн ослын газар руу хөдлөв.

Шинжлэн шалгах ажиллагааны дадлага сургалтыг бодит байдалд аль болох нийцүүлэх, шинжлэн шалгагч нарын байгаль, цаг агаарын онцгой нөхцөлд шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг хангах зорилгоор дараах чиглэлүүдээр зохион байгууллаа. Үүнд:

1. Ослын газарт хүрэх

1.1. Агаарын хөлгийн болзошгүй осол нь цаг хугацаа/өвөл-зун, халуун-хүйтэн/-ны болон газар зүйн байрлал /говь-цөл, уул-хад, гол-ус, намаг/-ны хувьд хэдийд ч, хаана ч болж болох тохиолдол юм. Дээрх нөхцөл байдалд тохируулан шинжлэн шалгах байгууллага нь шинжлэн шалгах ажиллагааны бэлэн байдлыг урьдчилан хангасан байх, шинжлэн шалгагч нар нь ослын газарт аль болох хурдан шуурхай очих шаардлагатай байдаг.

1.2. Дадлага сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 29-нд зохион байгуулахаар төлөвлөсөний дагуу 2ш Lexus GX470, Land cruiser 200 маягийн туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл бэлдсэн нь цаг хугацааны хувьд хурдан шуурхай зохион байгуулав.



Зураг 1. Сургалт дадлагад явах туулах чадвар сайтай тээврийн хэрэгслүүд.



Зураг 2. Төв офис дээр ХАБЭА - н зааварчилгаа болон бусад шаардлагатай мэдээлэл өгч байгаа байдал



Зураг 3. УАЗ. Пургон машинд зорчигч, ачааны байдал

1.3. Хээрийн нөхцөлд ажиллах ажилтнуудын хүнсний бүтээгдхүүнийг дэлгүүрийн нэхэмжлэхээр төлбөр тооцоо хийх ажлыг нягтлан бодогч хариуцан худалдан авалт хийсэн.

1.4. Улаанбаатараас 2025 оны 05 дугаар сар 29-ны өдрийн 09:35-д хөдлөн 11:40 цагт Хайртхаан амралтын районд очих цэг дээр ирсэн.



Зураг 4. Хээрийн нөхцөлд ажиллах багийн ачаа хөсөг, майхан.



Зураг 5. Хээрийн ажлын байр болох майхан барьж буй байдал



Зураг 6. Ажлын багийн майхан. /шаардлага хангахгүй актлах болсон байна/



Зураг 7. Шинжээчдийн майхан

1.5. Хүнсний ус, усны сав, тогоо, шанага, аяга халбага байхгүйгээс өдрийн хоол унд хийх хүндрэлтэй байлаа.

1.6. 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 11.00 цагийн орчимд очихоор тэмдэглэсэн газарт хүрч, өдрийн хоол ундыг /замдаа ус авсан/ бэлтгэсэн.

2. Газар дээрх ажиллагаа

2.1. 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10.00 цагт хээрийн ажлын байрыг бэлтгэн ослын газар дээрх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт, зааварчилгааг хийлээ.



Зураг 8. Газар дээр ахлах шижлэн шалгагч болон ХАБЭА-н ажилтан нар нийт бүрэлдхүүнд зааварчилгаа өгч буй байдал.

2.2. Ослын газарт:

2.3. Ослын газрын нөхцөл байдал хүний амь аврах сургалт

Агаарын хөлөгт байгаа хүмүүс нас барсан, хүнд гэмтэл авсан, агаарын хөлгөөс салсан хэсгүүдтэй шууд харьцсаны улмаас хавчуулагдсан байдалтай, агаарын хөлөг үндсэндээ бүтцийн хувьд эвдрэлд орсон байдлыг тогтоох. /Дадлага сургалт/

Агаарын хөлгийн гэмтлийн зэрэглэлийг тодорхойлох, түргэн тусламжийн автомашин, нисдэг тэргийг дуудах.

2.4. Аяны зориулалтын майханг барьж хээрийн түр штаб байгуулах шинжээчдийн ажиллах нөхцлийг бүрдүүлж биологийн болон халдваргүйжүүлэлтийн хамгаалалтын хувцас өмсүүлж зааварчилгааг ахлах шинжлэн шалгагч өгөв.

2.5. Ослын эд мөрийн баримтыг баталгаажуулан зураг авах.

2.5.1. Сансрын ИРИДУМ утсыг ашиглаж орон нутгийн хүчний болон эмнэлгийн байгууллагуудад мэдээлэв.

2.6. Нэрвэгдэгсдийг тээвэрлэх тусламжийн нисдэг тэрэг буух талбайг сонгох, эмнэлэгийн тусламж үзүүлэх.

2.7. Нэрвэгдэгсдийг аврах үйл ажиллагааг явуулахдаа уулархаг газар чулууны нуралт цасны нуранга, бөглүү газар зэрэг аюултай бүсүүдээс аль болох хурдан зайлуулж бололцоот эмнэлгийн тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэг хийхдээ дамнуурга эсвэл гар тээвэрлэлт хийх олс, татлага зэргийг ашиглах.

2.8. Боломжтой бол ослын газрын гэрчийг олж мэдүүлэг авах арга хэмжээг явуулах.

2.9. Нэрвэгдэгсдийг тээвэрлэх ажиллагааны дараа төв офисст байрлах жижүүрийн шинжээчтэй холбогдож зохион бүтээгч, үйлдвэрлэгчид мэдээлэх, ослын тухай мэдээлэл өгөх, агаарын хөлгийн эд ангийг шийдвэр иртэл үл хөдөлгөх эсвэл гарцаагүй тохиолдолд хөдөлгөх шийвэрүүдийг гаргуулах.

2.10. Осол болсон газарт мэдээллийг Чикагогийн конвенцийн 13-р хавсралтын дагуу үйлдвэрлэгч болон зохион бүтээгч, үйл ажиллагаа эрхлэгч улсад аль болох нэн даруй боломжит хэлбэрээр формат агуулгын дагуу ИКАО-ийн аль нэг зөвшөөрөгдсөн хэлээр мэдээлэл хүргэх.

2.11. Агаарын хөлөг болон эд мөрийн баримтыг хамгаалах агаарын хөлгийг хамгаалалтад авах.

2.12. Хамгийн хурдан шийдвэрийг гаргаж агаарын хөлөгт байгаа аюултай ачааны мэдээлийг холбогдох улсуудад илгээх.

3. Шинжилгээний тухай /бактерийн эсрэг дадлага/

Голомттой газарт тусгай биологийн хувцасыг өмсөж тайлах дэс дараалал

Ажлын дараа бүх хувцсыг тайлж дууссаны дараа хамгийн сүүлд хамгаалалтын бээлийг тайлж устгах уутанд хийж шатаах цэг рүү хаях дасгалыг хүн тус бүр дадлага хийв.

3.1. Ослын газарт ажиллагсад биологийн халдварт өртөх магадлал өндөр байдаг тул түүнээс хамгаалах сургалтыг заавал зохион байгуулахыг олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/ түүний баримт бичиг DOC 7659-д заасны дагуу биологийн халдвар гэж юу болох, ямар ямар халдвар байж болох түүнээс хэрхэн хамгаалах мөн хамгаалах хэрэгслэл түүнийг өмсөх, тайлах, халдваргүйжүүлэх сургалтыг хийв.

3.1.1. Биологийн халдвараас хамгаалах хувцсыг өмсөх сургалт



Зураг 9. Хамгийн эхэнд резинэн гутал өмсөх



Зураг 10. Биологийн халдвараас хамгаалах хувцас өмсөж буй байдал.



Зураг 11. Биологийн хамгаалалтын хувцас хэрэглэл бүрэн өмссөн байдал.

3.1.2. Ашигласан биологийн халдвараас хамгаалах хувцсыг өөрт халдваргүйгээр тайлах, тусгай уутанд хийж устгах сургалт.



Зураг 12. Комбинзон, резинэн гутлыг дэс дараалалтай тайлах, хамгийн сүүлд бээлийг гадагш эргүүлж тайлж халдваргүйжүүлэх зориулалтын уутанд хийх

3.2. Ослын газарт цацраг идэвхт бодис байх магадлал их байдаг тул түүнийг олж илрүүлэх, аюултай ачаа тээвэрлэж явсан эсэхийг тээврийн баримт бичиг эсвэл агаарын тээвэрлэгчээс тодруулга авах, агаарын хөлгийн эд ангид энэ төрлийн бодис байгаа эсэхийг судлах, эмнэлгийн тоног төхөөрөмж ачиж явсан эсэхийг тодорхойлох болон цацрагаас хамгаалах, түүний хамгаалалтын хэрэгслийг ашиглах дадлага сургалтыг зохион байгууллаа.



Зураг 13. Цацраг идэвхт туяаны эсрэг хамгаалалтын хувцас хэрэглэл өмсөж буй байдал.



Зураг 14. Цацраг идэвхт туяаны эсрэг хамгаалалтын хувцас хэрэглэл өмссөн байдал.



Зураг 15. Эхэлж комбинзон өмсөнө, зориулалтын хувцас нь тугалган хамгаалалттай хүнд учир туслагч шаардлагатай

3.3. Ослын үлдэгдэл нь өргөн хэмжээнд цацагдаж тархсан байдаг тул тэдгээрийг олох хайх, хамтран ажиллахад богино долгионы холбооны хэрэгсэл чухал үүрэг гүйцэтгэдэг.

Богино долгионы холбоог ашиглах, түүний бэлэн байдлыг шалгах сургалтыг зохион байгуулав.

Шинжлэн шалгагч нар уулын оргил, бэлээс холбоо барьж шалгахад гар станцуудын гаралт, хүлээн авах чадвар сайн байна.

Харин 500м-ээс хол зайд ажиллах чадвар муу байлаа. Тус албанд богино долгионы Kenwood ТК-378 1 ш, Kenwood ТК-3107 2 ш гар станцийг 2008 онд авч ашигласан ба 2019 оны 10 сарын 19-ний өдөр дадлага сургалтанд хэрэглээд тухайн үед гарсан тайлан дүгнэлтэнд ашиглалтын хугацаа дууссан, хүрэлцээ хангалт муу байгааг дурьдсан боловч өнөөг хүртэл шинэчлээгүй байна.

Иймд цаашид даруйхан хүчин чадал сайтай богино долгионы гар станцуудаар солих, 5-6 гар станцтай болох шаардлагатай байна.



Зураг 16. Kenwood ТК-3107, Kenwood ТК-378 гар станц, цэнэглэгч



Зураг 17. Гар станцуудын ажиллагаанд суралцах, бэлтгэж байгаа байдал

3.4. Ослын газрын эд мөрийн баримтын зураг авах ажиллагаа нь шинжээч нарын чухал ажлын нэг хэсэг байдаг.

DOC 7659 P3. 2.2 ОСЛЫН ГЭРЭЛ ЗУРАГ. Шинжлэн шалгах ажиллагааны чухал хэсэг бол гэрэл зураг юм. Тодорхой, сайн авсан гэрэл зургууд нь шинжлэн шалгаагчид хурдан мууддаг нотлох баримтыг хадгалах, тайлан дахь мэдээллийг нотлох, шинжлэн шалгаагчийн дүгнэлтийг харуулах боломжийг олгодог. Ослын шинжлэн шалгаагч бүр гэрэл зураг авах анхан шатны мэдлэгтэй байх шаардлагатай.

Энэ нь шинжлэн шалгаагчийн чанартай гэрэл зураг авах эсвэл мэргэжлийн гэрэл зурагчинтай үр дүнтэй харилцах боломжийг олгодог.

DOC 7659 P3. 2.2 ACCIDENT INVESTIGATION PHOTOGRAPHY. Photography is an important element of the investigation process. Clear, well composed photographs allow the investigator to preserve perishable evidence, substantiate the information in the report, and illustrate the investigator's conclusions. Every accident investigator needs a basic knowledge of photography. This allows the investigator to take quality photographs or to communicate effectively with a professional photographer in order to obtain photographs that contribute to a clearly written report.

2.2.4 What to photograph at the accident site. The general rule in accident site photography is to start with the most perishable evidence and work to the least perishable evidence. DOC7659 P3



Зураг 18. Буруу авсан




Зураг 19. Зөв авсан

Тус албанд ашиглагдаж байгаа Canon IXUS110 IS, Nikon COOLPIX P900 загварын 2 дижитал зургийн аппаратаар шинжээч нар сургалт хийлээ. Сургалтыг дахин нарийвчлан сургах, мэргэжлийн зурагчдаар сургалт зохион байгуулах, хүчин чадал сайтай дуран авах шаардлагатай байлаа.



Зураг 20. Canon IXUS110 IS, Nikon Coolpix P900



Зураг 21. Зураг авах ажиллагаа

2.2.4 Ослын газар юуны зураг авах вэ. Ослын газрын гэрэл зургийн ерөнхий дүрэм бол хамгийн амархан мууддаг нотлох баримтаас эхэлж, хамгийн бага мууддаг нотлох баримтыг ашиглах явдал юм. DOC 7659 P3

3.5. Ослын байршилыг GPS-ээр тодорхойлох, тэмдэглэх нь мөн ослын газар дээрх эд мөрийн баримтын байрлалыг GPS-д тэмдэглэх зураглалыг гаргах сургалтыг зохион байгууллаа.

DOC 7659 P3. 2.1 ОСЛЫН БАЙРШИЛ. Осол гарсан газрын байршилыг тогтоож, тэмдэглэнэ.

Нөлөөллийн цэгийг тодорхойлох нь чухал бөгөөд хэрэв нэг байршилд биш бол сүйрлийн ихэнх хэсэг байгаа байрлал, сүйрлийн талбайн цар хүрээг тодорхойлох нь чухал юм. Үүнийг дэлхийн байршил тогтоох хиймэл дагуулын (GPS) хүлээн авагч, нисэхийн зураг эсвэл агаарын гэрэл зургийн тусламжтайгаар хялбархан хийж болно. GPS хүлээн авагчийг хэд хэдэн хэлбэрээр авах боломжтой.

Жижиг, зөөврийн хүлээн авагч нь ослын газрын байршил, тэр ч байтугай хог хаягдал дахь объектуудын хоорондох ерөнхий зайг тодорхойлоход хангалттай нарийвчлалтай байдаг. GPS хүлээн авагчтай зураг зурах талаар дэлгэрэнгүй ярилцахыг энэ бүлгийн 2.3.3-аас үзнэ үү. DOC 7659 P3

2.1 ACCIDENT LOCATION. The location of the accident site must be determined and recorded. It is important to identify the point of impact and if not at the same location the position where most of the wreckage is located and the extent of the wreckage field. This can most easily be done by the use of a Global Positioning Satellite (GPS) receiver and aeronautical charts or aerial photographs. GPS receivers are available in several forms. Small, portable receivers are sufficiently accurate to identify the accident site location and even general distances between objects in the debris pattern. See paragraph 2.3.3 of this chapter for detailed discussion of plotting with GPS receivers. DOC 7659 P3



Зураг 22. GPS Оллоо, GPS Magellan

3.6. Мөн ослын газар дээрх нөхцөл байдал, эд мөрийн баримтын зай хэмжээг тогтоох дадлага сургалт хийгдлээ. Гэвч осол болоход эд мөрийн баримт нь хоорондоо 200, 300.....1000м хол зайнд тархсан байдаг тул бидний хэрэглэж байгаа 50 м-ийн туузан хэмжигчээр хэмжих боломжгүй байлаа. Цаашид лазер хэмжигч авах шаардлагатай.



Зураг 23. Хэмжих туузан метр /50м урттай/

3.7. Иридиум 9555 сансрын холбооны утсыг ашиглаж сурах сургалт болон луужингаар байрлалаа олох, ашиглах сургалтуудыг газар дээр нь зохион байгуулав.



Зураг 24. Иридиум 9555 сансрын холбоо.



Зураг 25. Луужин.

3.8. Шинжлэн шалгагч нар нь ослын хүндрэлтэй газарт хүрч очих бие бялдарын чадвартай байх шаардлагатай.

Ослын газрыг олох, хайх ажиллагааны сургалтаар шинжлэн шалгагч нар ахуйн болон багаж хэрэгслээ авч өөр өөр чиглэлд далайн түвшнээс 1800-2000м өндөрт гарах дадлагын аялал хийлээ.



Зураг 26. Хойд уул руу

Агаарын хөлөг осолдож газар мөргөх үед агаарын хөлгөөс хэдэн зуун метр квадрат талбайг хамарсан шатахуун асгардаг.

Агаарын хөлгийн орчимд асгарсан түлшний улмаас түймэр гардаг учир гамшигт өртөгсдийг аврах ажиллагаа хүндрэл учруулдаг. Шинжлэн шалгагч нарт галын комбинзон хорт утааны баг хэрэглэх шаардлага ч гарч болох юм.

Зарим тохиолдолд ослын үед нисэх баг цахилгааны хүчдэл, галын краныг хаасан байдаг тул, түймэр гараагүй байх учир агаарын хөлгийн ойролцоо гал гаргах тамхи татахыг хатуу хориглоно.

4. Хэлэлцүүлэг /дүгнэлт/

4.1. 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр өглөөний цайны дараа дадлага сургалтын ажлаа дүгнэх хэлэлцүүлэг хийгдлээ. Хэлэлцүүлгээр бодит байдлаас үндэслэн засах залруулах зүйл байгааг тогтоолоо. Үүнд:

-Шинжлэн шалгагчдыг ослын газарт хүргэх унаа /Фургон 1ш, Туулах чадвар сайтай авто машин 1ш бэлтгэж, шатах тослох материал болон шатахуунаар хангах ажлыг зохион байгуулж холбогдох газартай гэрээ хийх.

- Осол гарсан үед нэн даруй явах ажиллагааг шуурхай болгох, томилолтын зардлыг тогтмол бэлэн байлгах боломжоор хангах,

- Осол гарсан үед цахилгаан тоног төхөөрөмжийн / зөөврийн компьютер, гар чийдэн, бусад батарей шаардлагатай хэрэгсэлд гэх мэт/ нөөц батарей авч бэлэн байлгах,

- Ослын газарт удаан хугацаагаар ажиллахад муудахгүй зарим хүнсний зүйл /давс, цай, гоймон г.м /-ийг урьдчилан бэлтгэх боломжийг судлах,

- Ослын газрын ажиллагаа нь хүнд нөхцөлд ажилладаг болохыг нийт хамт олонд ойлгуулах, ажлын баг байрлах хуучин майханг актлаж шинээр өвөл, намар, хаврын улиралд хэрэглэхэд тохиромжтой майхан шинээр худалдан авах, тогоо, шанага 2ш, цэвэр усны сав /20л- ийн багтаамжтай 3ш/, гал тогоонд хэрэглэгдэх болон хувь хүний аяга халбага, хутганы багц, мах гурилын мод 2ш, газын плитка, хэрэглэгдэх газ, гал тогооны цэвэрлэгээний шингэн, алчуур, салфетик худалдан авч бэлэн байлгах, дахин

дахин хэрэглэгдэх тул аяны уутан хөнжлийн даавууг хүний тоогоор шинээр авах шаардлагатай,

- Ажлын болон амрах байранд гэрэлтүүлэг шаардлагатай /лаа, чүдэнз, жижиг оврын цахилгаан үүсгэвэр/,

- Одоо байгаа жижиг майханы багтаамж бага, зуны нимгэн тул өвлийн зориулалттай дөрвөн хүний нэг майхан нэмж авах шаардлагатай,

- Хүчин чадал сайтай богино долгионы гар станцыг 5 ширхэгийг шинээр авах шаардлагатай,

- Уул, бартаанд тархаж байрласан эд мөрийн баримт, ослын газрын тархалтын зураг авах, тодорхойлоход “дрон” хэрэглэх зайлшгүй шаардлагатай,

- Нарийвчилсан зураг авахад шаардлагатай фото аппаратын дуран тус тус шаардлагатай болохыг энэ удаагийн сургалтаар дахин тодорхойлогдлоо.

- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэл болон шинжлэн шалгагчийн өвөл, зуны хувцасны хангалт боломжтой байна.

- Уулархаг хад асгатай газар нэрвэгдэгсдэд хүрэх урт хамгаалалтын олс татлага, карбин холбоос, метал зүсэх батерейт дискин таслагч хөрөө/модны ир/ усанд бол хөвөгч хантааз, завь түлэгдэлт болон хөлдөлтөд үзүүлэх анхны тусламжийн иж бүрдэлийг бий болгох шаардлагатай.

- Дуут болон гэрлэн дохио өгөх, пуужингаар дохио өгөх, шүгэлээр дохио өгөх зэрэг аргачилалд суралцаж, бүрдэлийг бий болгох.

- Хээрийн нөхцөлд ажиллах байр /майханг/ актлав, шинээр авах, бусад унтах байр/жижиг майхан/, ширээ сандал, пүүгээ, дэвсгэр шаардлага хангана.

- Шинжлэн шалгагчдыг “Цусаар үүсгэгдсэн эмгэг төрүүлэгчдийн халдвараас хамгаалах сургалтанд хамруулж гэрчилгээжүүлэх, эмийн сан, боолт ариутгалын бодисыг бэлэн байлгах ажлыг хийх.

- Осол, зөрчлийг шинжлэн шалгах шуурхай үйл ажиллагаа явуулах үед санхүүгийн асуудлыг шат дамжлагагүй, хурдан шийдвэрлэх шаардлагатай байна.

- Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дадлага сургуулилтыг сар улирал тутам хийж хэвшүүлж байх, ажлын байранд шинжээчдийн зааварчилгаа сургалтын техник хэрэгслэлийг багтаасан “Хөдөлмөр хамгаалалын кабинет” байгуулах саналтай.

- Хээрийн хуурай хүнсний нормыг шинээр тогтоож, хангах шаардлагатай .

Тайлан бичсэн:

Шинжлэн шалгагч

Ч.Шинэбаяр